



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/24

Арвайхээр

Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны "Журам батлах тухай" А/274 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ын 2.4, 2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай А/55 дугаар захирамжийн 9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрыг ажлын тусгай горимд 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ныг хүртэл шилжүүлсүгэй.

2. Ажлын тусгай горимд шилжүүлсэнтэй холбогдуулан сар шинийн баярын өдрүүдээр ажилтан албан хаагчид хөдөө орон нутаг, хол аймаг сумд руу явахгүй байх, холбоо барих хэрэгслийг нээлттэй байлгаж шаардлагатай тохиолдолд богино болон уртасгасан цагаар ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Байгууллагын ажилтан албан хаагчдад холбоо, зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Н.Энхцэцэг)-т даалгасугай.

4. Байгууллагын хэмжээнд ажиллах шуурхай штаб, эргүүл, жижүүрийг томилох, автомашинуудын бэлэн байдлыг хангах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн материалын нөөц бүрдүүлэн ажиллахыг Нийтлэг үйлчилгээний алба (Б.Нацаг)-нд даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100079